

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2024 ОНЫ
9 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Хийгдэх ажил	Хүрэх үр дүн	Хугацаа	Биелэлт
1	Хугацаатай мэдээ, тайлан гаргах	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг	Дараа сарын 02-ны дотор	2024 оны 9-р сарын байдлаар манай байгууллага 206,741.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 163,552.5 мянган төгрөгийг зарцуулж, 43,188.5 мянган төгрөг тайлант хугацаанд зарцуулагдаагүй байна.
		Шилэн дансны мэдээллийг нэгдсэн цахим санд оруулах	Дараа сарын 08-ны дотор	Тайлант хугацаанд оруулбал зохих 14 мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулсан.
		Ниймгийн даатгалын тайлан гаргаж, хүргүүлэх	Дараа сарын 05-ны дотор	8-р сарын НДШ-ийн тайланг хуулийн хугацаанд илгээж, тайлагнасан.
2	Аймгийн ОНХСангийн 2022-2024 оны 3 дугаар сар хүртлэх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна	09 сар	Байгууллагын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Аймгийн ОНХСангийн 2022-2024 оны 3 дугаар сар хүртлэх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалтын явц 95 хувьтай.
3	Аймгийн хөрөнгө оруулалтын ажлын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна	09 сар	Байгууллагын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Аймгийн ОНХСангийн 2022-2024 оны 2 дугаар сар хүртэлх хугацааны санхүүгийн баримтад хяналт шалгалт хийгдэж байна. Шалгалтын явц 95 хувьтай байна.
4	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангуулах	Хуулийн хэрэгжилт хангагдана	09 сар	Байгууллагын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Шивээговь сумын ОНХСангийн 1-7 сар, ОНӨГазрын 1-8 сарын мэдээ оруулалт, Аймгийн Нэгдсэн эмнэлэг, БТСГазрын 1-8 дугаар сарын тогтмол зардлын шилэн дансны мэдээллийг үнэн зөв оруулсан эсэхэд нэг бүрчилсэн хяналт шалгалт хийн зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ.

				Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нийт 50 байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. Тухайн сард Нийтийн номын сан, Боржигин өв музей, Шивээговь сумын ИТХ, Шивээговь сумын Ерөнхий боловсролын сургууль, Баянтал сумын Эрүүл мэндийн төв гэсэн газрууд нь хугацаа хоцроосон байна. Тайлант хугацаанд хуулийн хэрэгжилт 97 хувьтай.
5	Мэдээллийн ил тод байдлыг хангах	Мэдээллийн ил тод байдал хангагдах	09 сар	Мэдээллийн ил тод байдлыг хангаж, ойлгомжтой байлгах үүднээс байгууллагын веб хуудас болон самбарт 12 мэдээ мэдээллийг байршуулсан. Байгууллагын facebook хуудас https://www.facebook.com/profile.php?id=100090091147081/ -аар 14 мэдээллийг иргэд олон нийтэд түгээж ажиллалаа.
6	Бусад ажил	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна.	09 сар	Аймгийн удирдах ажилчдын шуурхай зөвлөгөөний 1 удаагийн хурлаас өгсөн 1 үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь Хяналт, шинжилгээ үнэлгээний хүргүүлсэн. 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хариуцсан талбайд мод арчилгаа, усалгааг хуваарийн дагуу хийж орчны хог хаягдлыг цэвэрлэн Хоггүй сүмбэр фэйсбүүк, байгууллагын фэйсбүүк хуудсанд байршуулсан. ЕБ-ын 1 дүгээр сургуулийн дотоод хяналтын багийн 6 ажилтанд "Байгууллагын дотоод хяналт хийх, бүтэц, чиг үүрэг, ач холбогдол" сэдвээр онол, арга зүйн сургалтыг зохион байгууллаа. Сургалтаар тус сургуулийн дотоод хяналтын журам, төлөвлөгөөн дээр ярилцаж арга зүйн зөвлөгөө өгөв. "ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ" СЭДЭВТ 2 өдрийн 16 цагийн сургалтанд байгууллагын ёс зүйн дэд хорооны дарга оролцов. Сургалтыг удирдлагын академийн багш Доктор, дэд профессор Ч.Эрдэнэчимэг, Доктор Ж.Алтайбаатар нар удирдан явуулав. Нийт сургалтанд хамрагдсан байгууллагуудын 55 албан хаагчаас 2 өдрийн турш идэвх оролцоотой байсан 2 албан хаагчийн нэгээр шалгарч дурсгалын зүйлээр шагнуулав.

				Аймгийн Нийтийн номын сангаас “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” 36 дахь удаагийн номын баярын арга хэмжээний хүрээнд төрийн албан хаагчдын дунд зохион байгуулсан монгол бичгийн уралдаанд байгууллагын 4 албан хаагч оролцсон. Төрийн албаны салбар зөвлөлийн “7:4:10” сургалтын хөтөлбөрийн дагуу 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн семинар сургалтад байгууллагын албан хаагчид хамрагдсан. 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Статистикийн хэлтсийн 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан нээлттэй хаалганы өдөрлөгт байгууллагын албан хаагчид оролцсон.
7	Сүмбэр сумын ОНХСангийн 2023-2024 оны 6 дугаар сар хүртэлх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга сайжирна бат	09 сар	Байгууллагын 2024 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу Сүмбэр сумын ОНХСангийн 2023-2024.06 дугаар сарын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалтын явц 95 хувьтай байна.
8	Баянтал сумын Соёлын төвийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Санхүүгийн сахилга сайжирна бат	09 сар	Байгууллагын 2024 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу Баянтал сумын Соёлын төвийн үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн. Шалгалтаар тус байгууллагын засаглал, эрсдлийн удирдлага, дотоод хяналтын үйл явц нь давтамжтай буюу дунд эрсдэлтэй үнэлэгдэж сайжруулах шаардлагатай гэсэн дүгнэлт өгөгв. Аудитаар илэрсэн 8 асуудлыг арилгуулахаар хугацаатай зөвлөмж хүргүүлэв.
9	Цөм сүрэг үржлийн төвийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Санхүүгийн сахилга сайжирна бат	09 сар	Аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 9 дүгээр удирдамжийн дагуу Цөм сүрэг үржлийн төвийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж байна. Аудитын явц 10 хувьтай үргэлжилж байна.
10	Шивээговь сумын Соёлын төвийн 2023-2024.07 сар хүртэлх үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	9 сар	Байгууллагын 2024 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу Шивээговь сумын Соёлын төвийн үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн. Шалгалтаар тус байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь давтамжтай буюу 2-р түвшин"-д байна гэж үнэлэгдсэн ба дотоод аудитаар илэрсэн 11 асуудлаас 9 нь буюу 81% нь нөлөө ихтэй “Хангалтгүй” гэсэн дүгнэлтийг өгч, байгууллагад 23 заалт бүхий хугацаатай зөвлөмжийг өгөв.

11	Шивээговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023-2024.08 сар хүртлэх үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	09 сар	Аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 10 дугаар удирдамжийн дагуу Шивээговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж байна. Аудитын явц 10 хувьтай үргэлжилж байна.
12	Боржигин чуулгын 2024.01-07 сар хүртлэх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна	09 сар	Байгууллагын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөө болон Соёлын сайдын баталсан удирдамжийн дагуу Боржигин чуулгын 2024.01-07 сар хүртлэх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар нийт 25,789.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 5,866.1 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгуулахаар, 46.4 мянган төгрөгийг хувь хүнд нөхөн олгуулахаар нийт 5,912.5 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт, 19,876.5 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлээ. Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг "дунд" эрсдэлтэй гэж үнэлэв.
13	Шивээговь сумын Соёлын төвийн 2024.01-07 сар хүртлэх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна	09 сар	Байгууллагын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөө болон Соёлын сайдын баталсан удирдамжийн дагуу Шивээговь сумын Соёлын төвийн 2024.01-07 сар хүртлэх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалтын явц 70 хувьтай.
14	Соёлын газрын 2024.01-07 сар хүртлэх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна	09 сар	Байгууллагын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөө болон Соёлын сайдын баталсан удирдамжийн дагуу Соёлын газрын 2024.01-07 сар хүртлэх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалтын явц 40 хувьтай.
15	Татварын газрын 2022-2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна	09 сар	Сангийн яамны нэгдсэн удирдамжаар Татварын газрын 2022-2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалтын явц 80 хувьтай.
16	Баянтал сумын ОНХСангийн 2023.09-2024.06 сар хүртлэх үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	09 сар	Баянтал сумын ОНХСангийн 2023-2024.7 сар хүртэлх үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн хяналтаар сангийн үйл ажиллагаанд тавих хяналт сул, албан хаагчдын хариуцлага сул байгаагаас тендер худалдан авалтын баримтын бүрдлийг бүрэн хангадаггүй, дутуу бүрдүүлдэг, техник тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл ашиглалтад хяналт тавьдаггүй зэрэг зөрчил илэрлээ. Шалгалтаар нийт 16,892.33 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 78,33

				мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоож, 16,813.0 мянган төгрөгийн зөвлөмж өгөв. Тиймээс тус сангийн үйл ажиллагааг бага эрсдэлтэй гэж дүгнэв.
17	Баянтал сумын Соёлын төвийн 2024.01-07 сар хүртлэх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга сайжирна бат	09 сар	Байгууллагын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөө болон Соёлын сайдын баталсан удирдамжийн дагуу Баянтал сумын Соёлын төвийн 2024.01-07 сар хүртлэх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалтын явц 30 хувьтай.
18	Боржигон өв музейн 2024.01-07 сар хүртлэх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга сайжирна бат	09 сар	Байгууллагын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөө болон Соёлын сайдын баталсан удирдамжийн дагуу Боржигон өв музейн 2024.01-07 сар хүртлэх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалтын явц 80 хувьтай.
19	Нийтийн номын сангийн 2024.01-07 сар хүртлэх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга сайжирна бат	09 сар	Байгууллагын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөө болон Соёлын сайдын баталсан удирдамжийн дагуу Нийтийн номын сангийн 2024.01-07 сар хүртлэх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалтын явц 70 хувьтай.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

Нягтлан бодогч:



Б.Аззаяа